



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Амьд сорьц, эмгэг эс судлалын
шинжилгээ хийх журмыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Амьд сорьцын эмгэг эд судлалын шинжилгээ хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлэг болон тусгай эмнэлгийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төв /Г.Уянга/, Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Ш.Энхтуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 164 дүгээр тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 06-д
А/07 дугаар тушаалын хавсралт

АМЬД СОРЬЦ, ЭМГЭГ ЭС СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар өвчтөний амьд сорьцын болон эмгэг эс судлалын шинжилгээг орчин үеийн түвшинд хийж, шинжлэх ухааны нотолгоонд суурилсан үндэслэлтэй онош тогтоохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Амьд сорьцын болон эмгэг эс судлалын шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгоно.

Хоёр. Эмгэг судлалын нэр томъёо

2.1. "Эмгэг судлал" гэж бие цогцос, эрхтэн тогтолцоо, эс, эсийн дэд бүтэц болон молекулын түвшинд гарсан эмгэг өөрчлөлт, түүнийг үүсгэгч шалтгаан, эмгэг жам, өрнөлт, даамжрал, үр дагавар, тавилантай нь холбон судалж, онош тогтоохыг;

2.2. "Эмгэг бүтэц судлал" гэж амьд сорьц (биопси), эмгэг эс судлал (цитопатологи) болон нас барагчийн цогцсын шинжилгээ (аутопси)-г хийж өвчин эмгэгийн нотолгоонд суурилсан төгсгөлийн онош тогтоох, үхлийн үндсэн болон шууд шалтгааныг тогтоохыг;

2.3. "Амьд сорьц (biopsy)-ын шинжилгээ" гэж өвчилсөн эрхтнээс дурандах, хатгах, цоолох, соруулах, наалдуулах болон мэс заслын ажилбараар авсан эдийн дээж дээр бичил харуурын түвшинд онош тогтоохыг;

2.4. "Эмгэг эс судлал (cytopathology)-ын шинжилгээ" гэж биеийн гадаад орчинтой харьцдаг эрхтэн, эдээс болон гадагш харьцдаггүй дотор цул эрхтэн, эд, шингэнээс ердийн болон нарийн зүүгээр хатгалт хийж бэлтгэсэн түрхэц, мэс заслын ба дурант багажаар авсан материал, шархлаа, шархнаас шууд бэлтгэсэн эсийн түрхцийг үзэж, онош тогтоохыг;

2.5. "Эмгэг гистологийн шинжилгээ" гэж амьд сорьцоор болон цогцсын шинжилгээний үед эд, эрхтэн тус бүрээс авч, зориулалтын аргуудаар боловсруулан бичил харуурын тусламжтайгаар шинжилж, эмгэг өвчний өөрчлөлт, дүгнэлт бичиж, онош тогтоохыг;

2.6. "Эмгэг судлалын дээж" гэж эмгэг эд судлал болон эмгэг эс судлалын шинжилгээнд зориулан авсан материалыг;

2.7. "Эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт" гэж цогцсын болон амьд сорьц, эмгэг эсийн түрхцэд илэрсэн макро болон микро өөрчлөлтийг бичгийн хэлбэрээр баталгаажуулахыг;

2.8. “Эмгэг судлалын онош” гэж эрхтэн тогтолцоо эмгэг эд, эс судлалын түвшинд гарсан өөрчлөлтийг олон улсын өвчний ангилал, нэршил, үе шат, зэрэглэл, хэлбэрийг зааж, бичиг баримтын хэлбэрээр баталгаажуулахыг;

Гурав. Эмгэг судлалын шинжилгээ хийх эрүүл мэндийн байгууллага

3.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлэг болон тусгай эмнэлэг эмгэг эд, эс судлалын шинжилгээ хийнэ.

3.2. Энэхүү журмын 3.1-т заасан эрүүл мэндийн байгууллага нь эмгэг судлалын шинжилгээний байр, цогцсын шинжилгээний багаж тоног төхөөрөмж, урвалж бодис, будгийн хангамжийг хариуцна.

3.3. Эмгэг эд, эс судлалын шинжилгээ хийх боломжгүй эрүүл мэндийн байгууллага гэрээний үндсэн дээр эмгэг судлалын шинжилгээ хийх, эмгэг эд-эс судлалын онош тавих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.4. Амьд сорьц, эмгэг эс судлалын шинжилгээнд зайн оношилгоог ашиглаж болно.

3.5. Эмгэг судлалын үндэсний төвийн лабораторид амьд сорьцын шинжилгээний материалыг хүргэх, хариу авахтай холбоотой тээврийн асуудлыг тухайн эрүүл мэндийн байгууллага хариуцна.

3.6. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас эмгэг судлалын шинжилгээтэй холбоотой хүсэлт гарган Эмгэг судлалын үндэсний төвөөс эмгэг судлаач эмчийг томилон ажиллуулах тохиолдолд холбогдох зардлыг тухайн хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллага хариуцна.

Дөрөв. Амьд сорьц, эмгэг эс судлалын шинжилгээ хийхэд баримтлах зарчим

4.1. Биеийн гадаргуу болон ил байрлалтай эрхтний гадаргуугаас амьд сорьцын шинжилгээг авахдаа зүсч, хусч, наалдуулах хэлбэрээр дээж авч илгээнэ.

4.2. Дурангийн шинжилгээгээ болон ажилбарын үед эдийн сорьц авахдаа чимхэх, таслах, зүсэх, соруулах аргаар, эсийг сойздох, наалдуулах, хусах аргуудыг хэрэглэнэ.

4.3. Нарийн зүүний хатгалтаар эдийн сорьц авахдаа дүрс оношилгооны аргын хяналтан дор зориулалтын зүүгээр эдээс шаардлага хангасан материалыг авна.

4.4. Цоолбор амьд сорьцыг хийхдээ зориулалтын зүүгээр ясыг цоолж, доторх агууламжтай нь хамт сорьц авна.

4.5. Мэс заслын нээлттэй ажилбарын үед амьд сорьцын шинжилгээг авахдаа тайрсан эдэд тэмдэг, тэмдэглэгээг тодорхой тавьж илгээнэ.

4.6. Хүний бие махбодиос авсан эд, эрхтэн, эсийн түрхцийг эмгэг судлалын лабораторид заавал илгээж, оношийг тогтоолгоно.

4.7. Онош тогтоохоор авсан амьд сорьцыг эмгэг судлалын лабораторид эдийг хувааж таллахгүй, бүтнээр нь илгээнэ. Эдийг хувааж өөр өөр лабораторид илгээснээр эдийн эмгэг бүтэц зүй алдагдаж, зөрүүтэй дүгнэлт гарах эрсдэлтэй тул эдийг хуваасан тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч хариуцлага хүлээнэ.

Тав. Амьд сорьц, эмгэг эд, эс судлалын материалыг лабораторид илгээх үйл ажиллагаа

5.1. Амьд сорьцын дээжийг авмагц 10 хувийн саармагжуулсан буферт формалины уусмалд хийнэ. Бэхжүүлэлт хийснээс хойш дараа өдрийн 12 цагийн дотор лабораторид дагалдах бичгийн хамт илгээнэ.

5.2. Хөлдөөх зориулалт бүхий амьд сорьцыг бэхжүүлэх уусмалд хийлгүйгээр авсан даруйд дагалдах бичгийн хамт эмгэг, эд судлалын лабораторид хүргэнэ.

5.3. Гистохимийн шинжилгээнд зориулсан амьд эд сорьцыг Карнаугийн болон зориулалтын шингэнд хийнэ.

5.4. Нян бичил бүтцийн шинжилгээнд зориулсан амьд эд сорьцыг буферт глицероальдегидын шингэнд хийнэ.

5.5. Шинжилгээний материал хийсэн савны гадна талд өвчтөний овог нэр, нас хүйс, шинжилгээ авсан он, сар, өдөр, эд эрхтний нэрийг бичсэн шошго нааж, эмчлэгч эмч нь илгээлтийн маягтын дагуу бүрэн гүйцэд, үнэн зөв, гаргацтай бичиж, дээжийн хамт хүргүүлнэ.

5.6. Өвчний онош тогтоох зорилгоор болон мэс заслаар авсан эд, эрхтэнг шинжлүүлэх, түүнд хяналт тавих ажлыг мэс засал хийсэн эмч, эмчлэгч эмч нар шууд хариуцна.

5.7. Шинжилгээ хийх байгууллага дараах тохиолдолд шинжилгээний дээжийг шаардлага хангаагүй гэж үзэн хүлээн авалгүй тухайн эрүүл мэндийн байгууллагад буцаана:

5.7.1. Бэхжүүлээгүйгээс хатсан, ялзарсан, бэхжүүлэх шингэн нь шаардлага хангаагүй;

5.7.2. Нэр хаяг байхгүй, дагавар бичиггүй дээж;

5.7.3. Лабораторид ирүүлсэн амьд сорьцын материал нь дагавар бичигтэйгээ тохирохгүй байх;

Зургаа. Дээж хүлээлцэх

6.1. Эмгэг судлалын лабораторид шинжилгээний дээжийг хүргэж өгөх үүрэгтэй ажилтан нь дээж, дагавар бичгийн хамт биечлэн хүлээлгэж өгнө.

6.2. Шинжилгээний дээжийг хүлээн авсан эмч, лаборант уг эдээс шинжилгээнд авч, үлдсэн эдийг нэг сарын дотор архивлан хадгална. Хэрэв шинжилгээний материалыг хадгалах шаардлагагүй бол шинжилгээнд нөөцөлсний дараа эмгэг судлалын нэгжийн ахлагч устгалд оруулна.

6.3.Эмгэг эд судлалын лаборант шинжилгээнд авсан эдийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, шинжилгээний дугаарыг илгээлт бичиг болон бүртгэлд тодорхой тэмдэглэл үйлдэж, архивт хадгална.

Долоо. Шинжилгээний хариу гарах үйл явц

7.1. Эсийн шинжилгээг ажлын 2-3 өдөрт, дурангийн болон оношилгооны жижиг эдийн шинжилгээг ажлын 3-5 өдөрт, мэс заслаар авсан эд эрхтний шинжилгээг ажлын 5-7 өдөрт, онош тодруулах зорилгоор дархлаа гистохимийн шинжилгээ хийх шаардлагатай эдийн шинжилгээг ажлын 5 өдөрт багтаан хийж, хариу гаргана.

7.2. Мэс заслын явцад яаралтай шинжилгээ хийх тохиолдолд эдийг хөлдөөн, зүсэж 30-45 минутын дотор урьдчилсан дүгнэлт гаргана.

7.3. Шинжилгээний хариу нь бичлэг, онош, дүгнэлт гэсэн хэсгээс бүрдэнэ. Шинжилгээг хийсэн эмч, лаборант "Сорьцын шинжилгээний илгээлт" маягтыг бөглөж, гарын үсэг зурж баталгаажуулна.

7.4. Шинжилгээний бичлэг, оношийн талаар бүртгэлийн дэвтэрт бичиж, түүнийг хүлээж авсан хүний нэрийг тодорхой гаргацтай бичсэн байна.

Найм. Шинжилгээний дээж материалыг хадгалах хугацаа

8.1.Эмгэг судлалын шинжилгээний эрхтэн эдийн биет бэлдмэлийг 1 сар хүртэл, эсийн шинжилгээний бэлдмэлийг 5 жил, амьд сорьцын цутгамал болон эдийн бичил бэлдмэлийг 10 жил тус хадгална.

Ес. Амьд сорьц, мэс заслын материалыг устгах үйл ажиллагаа

9.1. Эмгэг судлалын дээж болон нөөцөд авсны дараа үлдсэн эдийн зүйлс, мэс заслаар тайрагдсан эрхтэн, үе мөчийг эдийн шинжилгээний хариу гарснаас хойш тухайн эрүүл мэндийн байгууллага болон Эмгэг судлалын үндэсний төв хариуцан устгана.

9.2. Эзэн нь буцааж аваагүй эрхтэн, ураг нярай, ихсийг тухай эрүүл мэндийн байгууллагын дарга, захирлын шийдвэрээр томилогдсон комисс холбогдох журмын дагуу устгана. Комиссын бүрэлдэхүүнд эмчлэгч эмч, эмгэг судлалын туслах ажилтныг оролцуулж, хэний ямар эрхтэнг яаж устгасан тухай тодорхой тэмдэглэл үйлдэж, тэмдэглэлийг комиссын дарга зориулалтын бүртгэлд бичиж, эмнэлгийн дүн бүртгэл, байгууллагын мэдээллийн албанд хадгална.